



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2022 оны 9 дүгээр
сарын 14-ний өдөр

Дугаар 346

Улаанбаатар
хот

Төрөөс олгох санхүүгийн дэмжлэг,
тэтгэлгийн талаар авах зарим
арга хэмжээний тухай

Боловсролын тухай хуулийн 43.2.9, Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 2, 30 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, Дээд боловсролын санхүүжилт, суралцагчдын нийгмийн баталгааны тухай хуулийн 8.1-д заасныг тус тус үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. “Монгол Улсын Ерөнхийлөгчийн нэрэмжит сургалтын тэтгэлэг олгох журам”-ыг 1 дүгээр хавсралт, “Монгол Улсын Ерөнхий сайдын нэрэмжит сургалтын тэтгэлэг олгох журам”-ыг 2 дугаар хавсралт, “Дээд боловсролын сургалтын байгууллагын суралцагчид төрөөс санхүүгийн дэмжлэг үзүүлэх журам”-ыг 3 дугаар хавсралт ёсоор тус тус шинэчлэн баталсугай.

2. “Журам батлах тухай” Засгийн газрын 2021 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн 347 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Боловсролын зээлийн сангийн хөрөнгийг зарцуулах, түүнд хяналт тавих журам”-д дор дурдсан агуулга бүхий 4.5, 5.1.3, 5.1.4, 8.4 дэх дэд заалтыг тус тус нэмсүгэй:

“4.5.Энэ журмын “Дөрөв” дэх хэсэг нь дэлхийн шилдэг их сургуулиудын зэрэглэл тогтоодог олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн “Times Higher Education World University Rankings” болон “Academic Ranking of World Universities” байгууллагын тогтоосон эрэмбээр тухайн жилийн эхний 50-д багтсан их, дээд сургуулийн бакалаврын үндсэн хөтөлбөрт суралцах, 50 ба түүнээс дээш хувийн сургалтын тэтгэлэг авсан суралцагчид олгох сургалтын төлбөрийн зээлд хамаарна.

5.1.3.Оюутны хөгжлийн зээлийг орон нутагт үйл ажиллагаа явуулж байгаа төрийн өмчийн их, дээд сургуульд бакалавр, магистр, докторын үндсэн хөтөлбөрт суралцагчийн сургалтын төлбөрийн 50 хүртэлх хувийг зээлээр олгоно;

5.1.4.Оюутны хөгжлийн зээлийг орон нутагт үйл ажиллагаа явуулж байгаа төрийн өмчийн их, дээд сургуульд суралцагчдад энэ журмын 5.1.1-д заасан тэргүүлэх болон эрэлттэй мэргэжил харгалзахгүй олгоно.

8.4.Зээлдэгч нас барсан, хөдөлмөрийн чадвараа бүрэн алдсаны улмаас суралцах боломжгүй болсныг нотолсон эрх бүхий байгууллагын шийдвэр, холбогдох баримтыг үндэслэн зээлийн төлбөрөөс бүрэн чөлөөлнө.”

3. Мөн журмын 5.1.2 дахь дэд заалтын “оюутны” гэсний дараа “өмнөх улирлын” гэж, 6.1 дэх заалтын “асуудал эрхэлсэн” гэсний өмнө “боловсролын болон санхүүгийн” гэж, 6.2 дахь заалтын “төлбөрийн” гэсний дараа “тэтгэлэг” гэж тус тус нэмсүгэй.

4. Мөн журмын 3.7 дахь заалтыг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“3.7.Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 23.6-д зааснаас гадна Боловсролын зээлийн санд зээлийн үлдэгдэлгүй суралцагчид зээл олгоно.”

5. Мөн журмын 2.6, 2.7, 6.1 дэх заалтын “захирал” гэснийг “дарга” гэж, 5.1.2 дахь дэд заалтын “хөгжлийн тэргүүлэгч” гэснийг “тэргүүлэх болон эрэлттэй” гэж, “5.1.3, 5.1.4, 5.1.5” дахь дэд заалтын дугаарыг “5.1.6, 5.1.7, 5.1.8” гэж тус тус өөрчилсүгэй.

6. Мөн журмын 3.3.3 дахь дэд заалтын “эрх бүхий гуравдагч этгээдээс батлан даалт гаргахад шаардагдах зардал” гэснийг, 5.1.2 дахь дэд заалтын “анх удаа” гэснийг, 6.1 дэх заалтын “мөн” гэснийг тус тус хассугай.

7. Мөн журмын 5.2, 5.3 дахь заалтыг тус тус хассугай.

8. Энэ тогтоолын 1-д заасан журмуудын хэрэгжилтийг удирдлага, зохион байгуулалтаар ханган шаардагдах хөрөнгийг жил бүрийн улсын төсөвт тусган, хяналт тавьж ажиллах, энэ тогтоол батлагдахаас өмнөх боловсролын зээлийн сангаас сургалтын төлбөрийн хөнгөлөлттэй зээлээр болон тэтгэлгээр суралцах гэрээ байгуулсан иргэдийн сургалтын төлбөрийн санхүүжилтийг гэрээнд заасан нөхцөлийн дагуу олгохыг Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан, Сангийн сайд Б.Жавхлан нарт даалгасугай.

9. Энэ тогтоол гарсантай холбогдуулан “Хөнгөлөлт үзүүлэх тухай” Засгийн газрын 2004 оны 8 дугаар сарын 5-ны өдрийн 167 дугаар тогтоол, “Журам шинэчлэн батлах тухай” Засгийн газрын 2021 оны 8 дугаар сарын 31-ний өдрийн 275 дугаар тогтоол, “Боловсролын зээлийн сангийн талаар авах зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын 2021 оны 8 дугаар сарын 25-ны өдрийн 264 дүгээр тогтоолын 1, 2 дахь заалтыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.



Монгол Улсын Ерөнхий сайд

Боловсрол, шинжлэх ухааны сайд

Л.ОЮУН-ЭРДЭНЭ

Л.ЭНХ-АМГАЛАН

Засгийн газрын 2022 оны 346 дугаар
тогтоолын 1 дүгээр хавсралт

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН НЭРЭМЖИТ
СУРГАЛТЫН ТЭТГЭЛЭГ ОЛГОХ ЖУРАМ

Нэг.Нийтлэг үндэслэл

1.1.Боловсролын тухай хуульд заасан Ерөнхийлөгчийн нэрэмжит сургалтын тэтгэлэг (цаашид “тэтгэлэг” гэх) олгохтой холбогдон үүсэх харилцааг энэ журмаар зохицуулна.

1.2.Монгол хүн бүрийг шилдэг, чанартай боловсрол эзэмших тэгш боломжоор бүрэн хангаж, орон нутгийнхаа хөгжилд хувь нэмрээ оруулах, эх оронч сэтгэлтэй, зөв хандлагатай, олон улсад өрсөлдөх чадвартай, бүтээлч, манлайлагч иргэнийг бэлтгэхэд энэ тэтгэлгийн ач холбогдол оршино.

1.3.Тэтгэлэг олгох үйл ажиллагаа нь ил тод, нээлттэй, шударга, ашиг сонирхлын зөрчлөөс ангид, орон зай, байршлаас үл хамааран иргэн бүрд тэгш боломжийг олгоно.

1.4.Монгол Улсын нийт сум, хороо тус бүрээс энэ журамд заасан шаардлага хангасан нэг иргэнийг тэтгэлгийн сонгон шалгаруулалтад оруулна.

1.5.Тухайн жилд тэтгэлгийн сонгон шалгаруулалтад тэнцсэн, энэ журмын шаардлагыг хангасан 500 хүртэлх суралцагчид тэтгэлэг олгоно.

1.6.Суралцагчид олгох зээл, тэтгэлгийн хэмжээ болон тэтгэлэг олгох суралцагчдын хяналтын тоог тэтгэлгийн төрөл тус бүрээр боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн тогтооно.

Хоёр.Тэтгэлгийн төрөл

2.1.Тэтгэлэг нь дараахь төрөлтэй байна:

2.1.1.дэлхийн шилдэг их сургуулиудын зэрэглэл тогтоодог олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн “Times Higher Education World University Rankings” болон “Academic Ranking of World Universities” байгууллагын тогтоосон эрэмбээр тухайн жилийн эхний 100-д багтсан их, дээд сургуулийн бакалаврын үндсэн хөтөлбөрт суралцуулах тэтгэлэг;

2.1.2.Засгийн газар хоорондын болон яам, боловсролын зээлийн сангийн түвшинд хийгдсэн хамтын ажиллагааны гэрээ, хэлэлцээрийн хүрээнд бакалаврын хөтөлбөрт суралцуулах тэтгэлэг;

2.1.3.боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас хүлээн зөвшөөрсөн олон улсын олимпиадад медальт байрт шалгарсан иргэнийг энэ журмын 2.1.1, 2.1.2-т заасан их, дээд сургуулийн бакалаврын үндсэн хөтөлбөрт суралцуулах тэтгэлэг;

2.1.4.бэлтгэл хөтөлбөрт суралцуулах тэтгэлэг (Энэ тэтгэлгийн хүрээнд гадаадын их сургуулийн суурь хөтөлбөрт, эсхүл дотоодын их сургуулийн бэлтгэл хөтөлбөрт суралцаж болно).

Гурав.Тэтгэлгийн сонгон шалгаруулалтын үе шат, шаардлага

3.1.Тэтгэлгийн сонгон шалгаруулалтыг бэлтгэл хөтөлбөрт болон тэтгэлэгт хөтөлбөрт сонгон шалгаруулах гэсэн хоёр үе шаттай зохион байгуулна.

3.2.Бэлтгэл хөтөлбөрт Монгол Улсын сум, хороо тус бүрээс дараахь шалгуур хангасан нэг иргэнийг сонгон шалгаруулна:

3.2.1.сүүлийн 3-аас доошгүй жил ерөнхий боловсролын сургуулийн хамран сургах тойргийн дагуу харьяалагдах сум, хороондоо суралцан төгссөн байх;

3.2.2.тухайн жилийн элсэлтийн ерөнхий шалгалтын “гадаад хэл-математик”, “гадаад хэл-физик”, “гадаад хэл-хими”, “гадаад хэл-биологи” гэсэн хувилбарын хэмжээст онооны дунджаар 550, түүнээс дээш оноо авсан байх;

3.2.3.энэ журмын 3.2.2-т заасны дагуу хэмжээст онооны дунджаар хамгийн өндөр оноо авч сум, хороондоо тэргүүлсэн байх.

3.3.Тухайн иргэн англи хэл, орос хэлний хичээлийн элсэлтийн ерөнхий шалгалтыг зэрэг өгсөн тохиолдолд гадаад хэлний хичээлийн элсэлтийн ерөнхий шалгалтын оноог аль өндөр оноо авсан хичээлийн оноогоор тооцно.

3.4.Энэ журмын 2.1.4-т заасан тэтгэлгээс өөрийн хүсэлтээр татгалзсан тохиолдолд онооны эрэмбээр авсан дарааллын дагуу иргэнийг бэлтгэл хөтөлбөрт элсүүлж болно.

3.5.Тэтгэлгийн бэлтгэл хөтөлбөрт хамрагдаж байгаа суралцагч нь хөтөлбөрийн хугацаанд эрүүл мэндийн болон бусад шалтгаанаар сургалтыг үргэлжлүүлэх боломжгүй болж өөрөө татгалзсан тохиолдолд тухайн суралцагчийн оронд сонгон шалгаруулалтыг дахин зохион байгуулахгүй.

3.6.Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын хүлээн зөвшөөрсөн олон улсын олимпиадад медальт байрт шалгарсан болон журмын 2.1.1-д заасан тэтгэлэгт хамаарах их, дээд сургуулийн албан ёсны урилга хүлээн авсан иргэн дотоодын их сургуулийн бэлтгэл хөтөлбөрт хамрагдахгүй байж болно.

3.7.Бэлтгэл хөтөлбөрийг амжилттай төгсөж, энэ журмын 2.1.1, 2.1.2-т заасан тэтгэлэгт хамаарах их, дээд сургуулийн албан ёсны урилга хүлээн авсан иргэнд тэтгэлэг олгох асуудлыг сонгон шалгаруулалтын Ажлын хэсэг шийдвэрлэнэ.

3.8.Бэлтгэл хөтөлбөрийг амжилттай дүүргэж чадаагүй иргэнийг дотоодын төрийн өмчийн их, дээд сургуульд хувийн хөрөнгөөр үргэлжлүүлэн суралцах боломжоор хангана.

3.9.Боловсролын асуудал хариуцсан орон нутгийн байгууллагын шийдвэрээр хамран сургах тойргийг өөрчилсөн нь энэ журмын 3.2.1-д заасан хугацааны шаардлагыг хангаагүй гэж үзэхгүй болно.

3.10.Энэ журмын 2.1.1-д заасан тэтгэлэгт хөтөлбөрт хамрагдах иргэнд дараахь ерөнхий шаардлага тавигдана:

3.10.1.их, дээд сургуулиас бакалаврын үндсэн хөтөлбөрт суралцах албан ёсны урилга авсан байх;

3.10.2.IELTS-ийн 6.5 буюу түүнээс дээш, IBT TOEFL-ийн 100-аас доошгүй оноотой байх эсхүл бусад гадаад хэлний эдгээртэй дүйцэхүйц олон улсын шалгалтын оноотой байх.

Дөрөв.Тэтгэлгийн сонгон шалгаруулалт,
тэтгэлэг олгох

4.1.Тэтгэлгийн сонгон шалгаруулалтын үйл ажиллагааг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нэгдсэн удирдлага, зохицуулалтаар хангана.

4.2.Тэтгэлэгт хөтөлбөрийн сонгон шалгаруулалтыг тухайн жилийн 2 дугаар улиралд, бэлтгэл хөтөлбөрийн сонгон шалгаруулалтыг 3 дугаар улиралд багтаан тус тус зохион байгуулна.

4.3.Боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний шийдвэрээр Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газар, холбогдох яам, агентлаг, иргэд, төрийн бус болон олон нийтийн байгууллагын төлөөллөөс бүрдсэн 11 гишүүний бүрэлдэхүүнтэй тэтгэлгийн сонгон шалгаруулалтыг зохион байгуулах Ажлын хэсгийг байгуулж, тэтгэлгийн сонгон шалгаруулалтын ажлын удирдамжийг батална.

4.4.Боловсролын үнэлгээний төв энэ журмын 3.2-т заасан шаардлага хангаж байгаа иргэдийн жагсаалтыг Монгол Улсын сум, хороо тус бүрээр гарган, аймаг, нийслэлийн боловсролын асуудал эрхэлсэн орон нутгийн захиргааны байгууллагатай хамтран хянаж баталгаажуулан боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

4.5.Тэтгэлгийн сонгон шалгаруулалтад тэнцсэн иргэдийн мэдээллийг Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газар, боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, сум, хорооны албан ёсны цахим хуудас болон олон нийтийн мэдээллийн хэрэгслээр нээлттэй, ил тод зарлана.

4.6.Суралцагчдын бэлтгэл хөтөлбөрт хамрагдах сургуулийн хуваарийг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хийнэ.

4.7.Суралцагчийн элсэлтийн ерөнхий шалгалтын оноо, бэлтгэл хөтөлбөрийн сурлагын амжилт, нэмэлт шалгалтын дүнгээр эрэмбэлж, энэ журмын 2.1.1, 2.1.2-т заасан тэтгэлэг олгоно.

4.8.Журмын 3.10-д заасан шаардлагыг хангаагүй суралцагчдыг бэлтгэл хөтөлбөрийн шалгалтын үнэлгээгээр эрэмбэлж, тэтгэлэг олгох асуудлыг сонгон шалгаруулалтын Ажлын хэсэг шийдвэрлэнэ.

4.9.Энэ журмын 2.1.1-2.1.3-т заасан тэтгэлэгт сургалтын болон оюутны дотуур байрны төлбөр, амьжиргааны тэтгэлэг, 2.1.4-т заасан тэтгэлгийн хүрээнд гадаадын их сургуулийн суурь хөтөлбөрт хамрагдах бол сургалтын болон оюутны дотуур байрны төлбөр, амьжиргааны тэтгэлэг, харин дотоодын их сургуулийн бэлтгэл хөтөлбөрт хамрагдах бол сургалтын болон оюутны дотуур байрны төлбөр тус тус хамаарна.

Тав.Тэтгэлгийн санхүүжилт

5.1.Тэтгэлгийн санхүүжилт нь дор дурдсан эх үүсвэрээс бүрдэнэ:

5.1.1.Боловсролын зээлийн сангийн хөрөнгө;

5.1.2. Засгийн газар хоорондын болон яам, боловсролын зээлийн сангийн түвшинд хийгдсэн хамтын ажиллагааны гэрээ, хэлэлцээрийн хүрээнд хэрэгжүүлж байгаа хөтөлбөрийн хөрөнгө.

Зургаа.Бусад

6.1.Тэтгэлгийн сонгон шалгаруулалтад тэнцсэн суралцагч, Боловсролын зээлийн сангийн Ажлын алба, тэтгэлэгт хамрагдсан иргэний харьяалагдах аймаг, нийслэлийн Засаг дарга нар гурвалсан гэрээ байгуулан, хяналт тавьж ажиллана.

6.2.Сонгон шалгаруулалтад тэнцэж тэтгэлэгт хамрагдсан суралцагч эрүүл мэндээс бусад шалтгаанаар суралцаагүй тохиолдолд төрөөс санхүүжүүлсэн санхүүжилтийг төрд буцааж бүрэн төлнө. Эрүүл мэндийн шалтгаанаар суралцах боломжгүй болсныг эрүүл мэндийн эрх бүхий байгууллагын шийдвэрээр нотолно.

6.3.Тэтгэлэгт хөтөлбөрт хамрагдсан иргэн сургуулиа төгссөний дараа энэ журмын 6.1-д заасан гэрээний дагуу засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжид 5-аас доошгүй жил ажиллана.

6.4.Тэтгэлгийн баримт бичгийг хуурамчаар бүрдүүлсэн, суралцагчийн мэдээллийг буруу гаргасан буюу сурлагын үнэлгээг бодитой бус үнэлсэн нь тогтоогдвол буруутай этгээдэд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

6.5.Сонгон шалгаруулалттай холбогдон гарсан маргааныг энэ журмын 4.3-т заасан Ажлын хэсэг шийдвэрлэнэ.

6.6.Энэ журмаар зохицуулаагүй бусад харилцааг холбогдох хууль тогтоомж, дүрэм, журмаар зохицуулна.

Засгийн газрын 2022 оны 346 дугаар
тогтоолын 2 дугаар хавсралт

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙДЫН НЭРЭМЖИТ
СУРГАЛТЫН ТЭТГЭЛЭГ ОЛГОХ ЖУРАМ

Нэг.Нийтлэг үндэслэл

1.1.Өмчийн бүх хэлбэрийн дээд боловсролын сургалтын байгууллага (цаашид “сургалтын байгууллага” гэх)-д зохих журмын дагуу бакалаврын хөтөлбөрт элсэн суралцаж байгаа шилдэг суралцагч болон гадаадын их, дээд сургуульд магистр, докторын үндсэн хөтөлбөрт суралцах иргэнд Монгол Улсын Ерөнхий сайдын нэрэмжит сургалтын тэтгэлэг (цаашид “тэтгэлэг” гэх) олгохтой холбогдон үүсэх харилцааг энэ журмаар зохицуулна.

1.2.Тэтгэлгийн зорилго нь “Шинэ сэргэлтийн бодлого”-ыг хэрэгжүүлэх, олон улсад өрсөлдөх мэдлэг чадвартай, нийгэм, эдийн засгийн хөгжилд хувь нэмэр оруулах, эх оронч иргэнийг хөгжүүлэх, шилдэг мэргэжилтэн-манлайлагчийг бэлтгэх, дэмжих, урамшуулах, сурталчлахад оршино.

1.3.Тэтгэлэгт энэ журмын “Хоёр”-т заасан шаардлагыг хангасан иргэнийг хамруулна.

1.4.Тэтгэлгийг дотоодын сургалтын байгууллага болон гадаадын их, дээд сургуульд суралцах иргэнд тус тус олгоно.

1.5.Тухайн жилд суралцагчид олгох тэтгэлгийн хэмжээ болон хяналтын тоог тэтгэлгийн төрөл тус бүрээр боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

Хоёр.Тэтгэлгийн шаардлага

2.1.Шилдэг суралцагчийн тэтгэлгийг дараахь шаардлага хангасан суралцагчид олгоно:

2.1.1.дотоодын сургалтын байгууллагын 2 ба 3 дугаар дамжааны өдрийн ангид суралцдаг байх;

2.1.2.бакалаврын хөтөлбөрөөр суралцагч сүүлийн 3 улирал дараалан 3.4 болон түүнээс дээш голч оноотой үнэлэгдсэн байх;

2.1.3.суралцагч нь зохих журмын дагуу сургалтын байгууллагад элссэн, боловсролын удирдлагын системд бүртгэгдсэн байх.

2.2.Соёл, урлаг, спортын чиглэлээр дараахь шаардлагыг хангасан дотоодын сургалтын байгууллагын суралцагчид тэтгэлэг олгоно:

2.2.1.олон улсын болон улсын хэмжээний оюутны соёл, урлагийн наадам, үзэсгэлэн, уралдаан тэмцээнд оролцож эхний гурван байрт шалгарсан байх;

2.2.2.спортын төрлөөр суралцагч нь олон улсын олимпын хорооны ивээл дор зохион байгуулагддаг дэлхийн болон тивийн аварга шалгаруулах тэмцээн, дэлхийн оюутны спортын наадамд оролцож медальт байрт шалгарсан, эсхүл шатар, даамын төрлөөр “Олон улсын хэмжээний мастер” цол хүртсэн байх.

2.3.Гадаадын их, дээд сургуульд магистр, докторын үндсэн хөтөлбөрт суралцах иргэн дараахь шаардлагыг хангасан байна:

2.3.1.дэлхийн шилдэг их сургуулиудын зэрэглэл тогтоодог “Times Higher Education World University Rankings” болон “Academic Ranking of World Universities” байгууллагын тогтоосон эрэмбээр тухайн жилийн эхний 100-д багтсан их, дээд сургуулийн магистр, докторын үндсэн хөтөлбөрт суралцах шаардлагыг хангаж, урилга авсан байх;

2.3.2.IELTS-ийн 6, IBT TOEFL-ийн 90 оноо эсхүл бусад гадаад хэлний эдгээртэй дүйцэхүйц олон улсын шалгалтын онооны шаардлага хангасан байх.

Гурав.Тэтгэлгийн сонгон шалгаруулалт

3.1.Тэтгэлгийн сонгон шалгаруулалтыг Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хамтран нэгдсэн удирдлага, зохицуулалтаар хангана.

3.2.Боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний шийдвэрээр Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, холбогдох яам, агентлаг, иргэд, төрийн бус болон олон нийтийн байгууллагын төлөөллөөс бүрдсэн 9 гишүүний бүрэлдэхүүнтэй тэтгэлгийн сонгон шалгаруулалтыг зохион байгуулах Ажлын хэсгийг байгуулж, тэтгэлгийн сонгон шалгаруулалтын ажлын удирдамжийг батална.

3.3.Тэтгэлгийн сонгон шалгаруулалтыг 2 үе шаттай зохион байгуулах бөгөөд сонгон шалгаруулалтын зарыг Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын албан ёсны цахим хуудас болон олон нийтийн мэдээллийн хэрэгслээр нээлттэй, ил тод зарлана.

3.4.Тэтгэлэгт хамрагдах иргэн нь журамд заасан шаардлагыг хангасныг нотлох баримт бичгийг бүрдүүлэн боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын цахим хуудсанд бүртгүүлнэ.

3.5.Эхний шатны сонгон шалгаруулалтын үйл ажиллагааг цахимаар ирүүлсэн иргэний баримт бичигт үндэслэн шалгах бөгөөд хугацаа хожимдуулсан, баримт бичгийн бүрдүүлэлт дутуу тохиолдолд сонгон шалгаруулалтад оролцуулахгүй.

3.6.Тэтгэлгийн сонгон шалгаруулалтыг холбогдох хэвлэл мэдээллийн байгууллагатай хамтран ил тод, нээлттэй, шударга, ашиг сонирхлын зөрчлөөс ангид, суралцагч бүрд цаг хугацаа, орон зай, байршлаас үл хамаарсан тэгш боломж олгох хэлбэрээр зохион байгуулна.

Дөрөв.Тэтгэлэг олгох

4.1.Тэтгэлгийн сонгон шалгаруулалтад тэнцсэн суралцагчид дараахь тэтгэлгийг олгоно:

4.1.1.энэ журмын 2.1, 2.2-т заасан шаардлагыг ханган дотоодын сургалтын байгууллагад суралцах 50 хүртэлх суралцагч тус бүрд 10,000,000.0 (арван сая) хүртэл төгрөгийн тэтгэлэг;

4.1.2.энэ журмын 2.3-т заасан шаардлагыг хангасан дэлхийн шилдэг их, дээд сургуульд магистр, докторын үндсэн хөтөлбөрөөр суралцах 50 хүртэлх суралцагчид сургалтын төлбөрийн тэтгэлэг.

4.2.Энэ журмын 4.1.2-т заасан суралцагчид тэтгэлгийг сургалтын хөтөлбөрт заасан хугацаанд олгоно.

Тав.Тэтгэлгийн санхүүжилт

5.1.Тэтгэлгийн санхүүжилт нь дор дурдсан эх үүсвэрээс бүрдэнэ:

5.1.1.Боловсролын зээлийн сангийн хөрөнгө;

5.1.2.Засгийн газар хоорондын болон яам, боловсролын зээлийн сангийн түвшинд хийгдсэн хамтын ажиллагааны гэрээ, хэлэлцээрийн хүрээнд хэрэгжүүлж байгаа хөтөлбөрийн хөрөнгө.

Зургаа.Тэтгэлэгт хамрагдах суралцагчийн хариуцлага

6.1.Сонгон шалгаруулалтад тэнцэж тэтгэлэгт хамрагдсан суралцагч эрүүл мэндээс бусад шалтгаанаар суралцаагүй тохиолдолд төрөөс санхүүжүүлсэн санхүүжилтийг төрд буцааж бүрэн төлнө. Эрүүл мэндийн шалтгаанаар суралцах боломжгүй болсныг эрүүл мэндийн эрх бүхий байгууллагын шийдвэрээр нотолно.

6.2.Энэ журам нь хоёр дахь удаагаа гадаадын их, дээд сургуульд магистр, докторын хөтөлбөрт суралцах суралцагчид хамаарахгүй.

Долоо.Бусад


7.1.Тэтгэлгийн сонгон шалгаруулалтад тэнцсэн суралцагчтай Боловсролын зээлийн сан гэрээ байгуулж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллана.

7.2.Тэтгэлгийн сонгон шалгаруулалтын явцад ашиг сонирхлын зөрчил үүссэн, тэтгэлгийн баримт бичгийг хуурамчаар бүрдүүлсэн, суралцагчийн мэдээллийг буруу гаргасан буюу сурлагын үнэлгээг бодитой бус үнэлсэн нь тогтоогдвол буруутай этгээдэд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

7.3.Сонгон шалгаруулалттай холбогдон гарсан маргааныг энэ журмын 3.2-т заасан Ажлын хэсэг шийдвэрлэнэ.

7.4.Энэ журмаар зохицуулаагүй бусад харилцааг холбогдох хууль тогтоомж, дүрэм, журмаар зохицуулна.

Засгийн газрын 2022 оны 346 дугаар
тогтоолын 3 дугаар хавсралт



ДЭЭД БОЛОВСРОЛЫН СУРГАЛТЫН БАЙГУУЛЛАГЫН
СУРАЛЦАГЧИД ТӨРӨӨС САНХҮҮГИЙН ДЭМЖЛЭГ
ҮЗҮҮЛЭХ ЖУРАМ

Нэг.Нийтлэг үндэслэл

1.1.Дээд боловсролын сургалтын байгууллага (цаашид “Сургалтын байгууллага” гэх)-ын суралцагчид төрөөс санхүүгийн дэмжлэг үзүүлэхтэй холбогдон үүсэх харилцааг энэ журмаар зохицуулна.

1.2.Сургалтын байгууллагын суралцагчид төрөөс санхүүгийн дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаанд Засгийн газрын тусгай сангийн тухай хууль, Дээд боловсролын тухай хууль, Дээд боловсролын санхүүжилт, суралцагчдын нийгмийн баталгааны тухай хууль, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль, Төсвийн тухай хууль, Засгийн газраас баталсан “Боловсролын зээлийн сангийн хөрөнгийг зарцуулах, түүнд хяналт тавих журам” болон холбогдох бусад хууль тогтоомж, энэ журмыг баримтална.

1.3.Энэ журмыг хэрэгжүүлэх үйл ажиллагаа, сонгон шалгаруулалт нь шударга, ил тод, нээлттэй, тэгш боломжийг хангах зарчмыг баримтална.

1.4.Санхүүгийн дэмжлэгт хамрагдах суралцагч нь зохих журмын дагуу сургалтын байгууллагад элссэн, боловсролын удирдлагын системд бүртгэгдсэн байна.

1.5.Санхүүгийн дэмжлэгт сургалтын төлбөрийн буцалтгүй тусламж, тэтгэлэг, амьжиргааны зардал, сургалтын төлбөрийн зээл, оюутны дотуур байрны төлбөр орно.

Хоёр.Санхүүгийн дэмжлэгт хамрагдах суралцагчид

2.1.Төрөөс үзүүлэх санхүүгийн дэмжлэгт дээд боловсролын сургалтын байгууллагын дараахь суралцагч хамрагдана:

2.1.1.Монгол Улсын Ерөнхийлөгчийн нэрэмжит сургалтын тэтгэлгээр суралцагч;

2.1.2.Монгол Улсын Ерөнхий сайдын нэрэмжит сургалтын тэтгэлгээр суралцагч;

2.1.3.бүтэн өнчин суралцагч;

2.1.4.хөгжлийн бэрхшээлтэй бакалавр, магистр, докторын хөтөлбөрт суралцагч;

2.1.5.эцэг, эх нь хоёулаа хөгжлийн бэрхшээлтэй бакалаврын хөтөлбөрт суралцагч;

2.1.6.хөдөлмөрийн чадвараа бүрэн алдсан гишүүнтэй өрхийн бакалаврын хөтөлбөрийн нэг суралцагч;

2.1.7.цаатан өрхийн бакалаврын хөтөлбөрт суралцагч;

2.1.8.нэг гэр бүлийн 3 болон түүнээс дээш хүүхэд дотоодын сургалтын байгууллагад бакалаврын хөтөлбөрт зэрэг суралцаж байгаа тохиолдолд нэг суралцагч;

2.1.9.орон нутагт үйл ажиллагаа явуулж байгаа төрийн өмчийн их, дээд сургуулийн бакалавр, магистр, докторын үндсэн хөтөлбөрт суралцагч;

2.1.10.“Монголын сайхан бичигтэн” уралдааны эхний гурван байрт шалгарсан суралцагч;

2.1.11.төрийн өмчийн их, дээд сургуульд багш мэргэжлээр суралцагч;

2.1.12.өмчийн бүх хэлбэрийн сургалтын байгууллагад сувилагч мэргэжлээр суралцагч;

2.1.13.төрийн өмчийн их, дээд сургуульд хөдөлгөөн засалч, хөдөлмөр засалч мэргэжлээр суралцагч;

2.1.14.аймгийн төв хүртэл 500 км болон түүнээс хол байршилтай сургалтын байгууллагад суралцагч;

2.1.15.Засгийн газар хоорондын болон яам, Боловсролын зээлийн сангийн түвшинд хийгдсэн хамтын ажиллагааны гэрээ, хэлэлцээрийн дагуу Монгол Улсын дээд боловсролын сургалтын байгууллагад гадаад орноос суралцагч;

2.1.16.Эрх бүхий байгууллагаас баталсан Монгол Улсад шаардлагатай тэргүүлэх болон эрэлттэй мэргэжлээр дотоодын сургалтын байгууллагад бакалавр, магистр, докторын үндсэн хөтөлбөрт суралцагч;

2.1.17.дэлхийн шилдэг их сургуулиудын зэрэглэл тогтоодог олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн “Times Higher Education World University Rankings” болон “Academic Ranking of World Universities” байгууллагын тогтоосон эрэмбээр тухайн жилийн эхний 50-д багтсан их, дээд сургуулийн бакалаврын үндсэн хөтөлбөрт суралцах, 50 ба түүнээс дээш хувийн сургалтын тэтгэлэг авсан суралцагч;

2.1.18.Засгийн газар хоорондын гэрээ, хэлэлцээрийн дагуу гадаадын их дээд сургуульд бакалавр, магистр, докторын хөтөлбөрт суралцагч.

Гурав. Санхүүгийн дэмжлэгийн төрөл,
тавигдах шаардлага

3.1.Энэ журмын 2.1.1, 2.1.2-т заасан суралцагчид Засгийн газраас баталсан Монгол Улсын Ерөнхийлөгчийн болон Ерөнхий сайдын нэрэмжит сургалтын тэтгэлэг олгох журмын дагуу тус тус олгоно.

3.2. Дараахь санхүүгийн дэмжлэгийг буцалтгүй тусламж хэлбэрээр олгоно:

3.2.1. энэ журмын 2.1.3-2.1.8, 2.1.10, 2.1.13-т заасан суралцагчид тухайн хичээлийн жилд 30 багц цаг хүртэлх хэмжээний сургалтын төлбөр;

3.2.2. энэ журмын 2.1.9-д заасан бакалаврын үндсэн хөтөлбөрт суралцагчид 50 хувийн сургалтын төлбөр;

3.2.3. энэ журмын 2.1.11-д заасан суралцагч нь шинээр элсэгч бол элсэлтийн ерөнхий шалгалтын дундаж 650-750 оноо авсан тохиолдолд 70 хувийн, 751-ээс дээш оноо авсан тохиолдолд 100 хувийн, үргэлжлүүлэн суралцагч бол өмнөх улиралд 2.8-3.0 хүртэл голч дүнтэй суралцсан тохиолдолд 70 хувийн, 3.0 болон түүнээс дээш голч дүнтэй суралцсан тохиолдолд 100 хувийн сургалтын төлбөр;

3.2.4. энэ журмын 2.1.12-т заасан суралцагч дээд боловсролын дипломын болон бакалаврын хөтөлбөрт элсэгч бол элсэлтийн ерөнхий шалгалтын дундаж 501-ээс дээш оноо авсан тохиолдолд хичээлийн жилийн эхний улирлын 100 хувийн, үргэлжлүүлэн суралцагч өмнөх улиралд 2.8-3.0 хүртэл голч дүнтэй суралцсан тохиолдолд 70 хувийн, 3.0 болон түүнээс дээш голч дүнтэй суралцсан тохиолдолд 100 хувийн сургалтын төлбөр;

3.2.5. энэ журмын 2.1.11-д заасан суралцагч хөдөө, орон нутагт багшлах дадлага гүйцэтгэх тохиолдолд тухайн сургуулийн нэг хичээлийн жилийн сургалтын төлбөрийн 30 хувьтай тэнцэх хэмжээний амьжиргааны тэтгэлэг;

3.2.6. энэ журмын 2.1.14-т заасан суралцагчид өвлийн амралтаараа аймгийн төвд очих, ирэх унааны зардлыг зорчигч тээврийн тарифаар тооцон олгох санхүүгийн дэмжлэг;

3.2.7. энэ журмын 2.1.15-т заасан суралцагч бол холбогдох гэрээ, хэлэлцээр, хөтөлбөрт заасан болон сантай байгуулсан гэрээний нөхцөлийн дагуу олгох санхүүгийн дэмжлэг.

3.3. Энэ журмын 2.1.3-2.1.8, 2.1.13-т заасан суралцагчид өмнөх улирлын голч дүн 2.0 болон түүнээс дээш, 2.1.9-2.1.10-д заасан суралцагчийн өмнөх улирлын голч дүн 2.8 болон түүнээс дээш, магистр, докторын хөтөлбөрийн суралцагчийн өмнөх улирлын голч дүн 3.2 болон түүнээс дээш үнэлэгдсэн байх тохиолдолд сургалтын төлбөрийг үргэлжлүүлэн олгоно.

3.4. Дараахь санхүүгийн дэмжлэгийг сургалтын төлбөрийн зээл хэлбэрээр олгоно:

3.4.1. энэ журмын 2.1.9-д заасан суралцагчид 50 хувийн сургалтын төлбөрийн зээл;

3.4.2. энэ журмын 2.1.16-д заасан суралцагч нь шинээр элсэгч бол элсэлтийн ерөнхий шалгалтын дундаж 600 болон түүнээс дээш оноо авсан тохиолдолд 100 хувийн сургалтын төлбөрийн зээл;

3.4.3. энэ журмын 2.1.17, 2.1.18-д заасан суралцагчид сургалтын төлбөрийн зээл.

3.5.Энэ журмын 2.1.9-д заасан суралцагч өмнөх улиралд 2.8 болон түүнээс дээш, мөн журмын 2.1.16-д заасан бакалаврын хөтөлбөрт суралцагч өмнөх улиралд 2.8 болон түүнээс дээш, магистрант, докторантын хөтөлбөрт 3.2 болон түүнээс дээш, журмын 2.1.17, 2.1.18-д заасан суралцагч өмнөх улиралд 2.8 болон түүнээс дээш голч дүнтэй үнэлэгдсэн байх тохиолдолд сургалтын төлбөрийн зээлийг үргэлжлүүлэн олгоно.

3.6.Сургалтын байгууллагад эрэлттэй мэргэжлээр суралцагчид сургалтын төлбөрийн зориулалтаар банк, санхүүгийн байгууллагаас зээл (хөнгөлөлттэй эргэн төлөгдөх нөхцөлөөр олгох мөнгөн хөрөнгө) авахад хүүгийн хөнгөлөлт үзүүлнэ.

3.7.Суралцагч Боловсролын зээлийн сангаас авсан зээлээ төлөөгүй, гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй, хуурамч баримт бичиг бүрдүүлсэн тохиолдолд сургалтын төлбөрийн зээл олгохгүй.

Дөрөв. Санхүүгийн дэмжлэгт хамрагдах суралцагчийн бүрдүүлэх баримт бичиг

4.1.Санхүүгийн дэмжлэг авахад дараахь баримт бичгийг бүрдүүлнэ:

4.1.1.иргэний үнэмлэхийн хуулбар;

4.1.2.зээл, тэтгэлэг хүссэн өргөдөл;

4.1.3.элсэлтийн ерөнхий шалгалтын батламж (шинээр элсэгч);

4.1.4.суралцагчийн голч дүнг тусгасан сургуулийн тодорхойлолт;

4.1.5.тухайн улиралд судалж байгаа хичээлийг баталгаажуулсан жагсаалт;

4.1.6.төлбөрийн нэхэмжлэхийн эх хувь;

4.1.7.багш бэлтгэдэг төрийн өмчийн их, дээд сургуульд амжилттай суралцаж байгаа дүнгийн тодорхойлолт болон хөдөө, орон нутагт багшлах дадлагын удирдамж, нотлох баримт;

4.1.8.энэ журмын 3.2.6-д заасан тусламжид хамрагдах бол зам, тээврийн хөгжлийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний баталсан жишиг тарифаар төлсөн оюутны өвлийн амралтын 2 талын зардлын баримтын эх хувь;

4.1.9.энэ журмын 3.2.1-3.2.5, 3.2.7-д заасан суралцагчийн хувьд эрх бүхий этгээдийн баталгаажуулсан холбогдох баримт бичиг, тодорхойлолт;

4.1.10.дипломын хуулбар;

4.1.11.нийгмийн даатгалын шимтгэл төлсөн тухай лавлагаа;

4.1.12.IELTS, IBT TOEFL, бусад гадаад хэлний эдгээртэй дүйцэхүйц олон улсын шалгалтын шаардлага хангасан баримт;

4.1.13.дэлхийн шилдэг их сургуулиудын зэрэглэл тогтоодог олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн “Times Higher Education World University Rankings” болон “Academic Ranking of World Universities” байгууллагын тогтоосон эрэмбээр тухайн жилийн эхний 100-д багтсан их, дээд сургуулийн бакалаврын үндсэн хөтөлбөрт суралцах урилга;

4.1.14.суралцах зорилго, төлөвлөгөө, судалгааны ажлыг тодорхойлж бичсэн эссэ (1000-2000 үгтэй, монгол, англи хэлний аль нэгийг сонгох);

4.1.15.тодорхойлох захидал (суралцах арга барил, судалгаа, шинжилгээний ажлын туршлага, зан төлөвийн онцлогийг тодорхойлсон удирдагч багш, эрдэмтэн, байгууллагын тодорхойлолт);

4.1.16.эрдэм шинжилгээний бүтээлийн жагсаалт (докторын хөтөлбөрт хамрагдах тохиолдолд);

4.1.17.шаардлагатай бусад.

4.2.Суралцагч нь санхүүгийн дэмжлэгт хамрагдах тохиолдолд журмын 4.1-д заасан дараахь баримт бичгийг бүрдүүлнэ:

4.2.1.энэ журмын 2.1.2-т заасан гадаадын дээд боловсролын сургалтын байгууллагад магистр, докторын хөтөлбөрт суралцагч 4.1.1, 4.1.2, 4.1.10, 4.1.12, 4.1.13, 4.1.17-д заасан баримт бичиг;

4.2.2.энэ журмын 2.1.3-2.1.12-т заасан тэтгэлгээр суралцагч 4.1.1-4.1.11, 4.1.17-д заасан баримт бичиг;

4.2.3.энэ журмын 2.1.16-д заасан суралцагч 4.1.1-4.1.6-д заасан баримт бичиг;

4.2.4.энэ журмын 2.1.17-д заасан суралцагч 4.1.1, 4.1.2, 4.1.12-4.1.15, 4.1.17-д заасан баримт бичиг;

4.2.5.энэ журмын 2.1.18-д заасан суралцагч 4.1.1, 4.1.2, 4.1.10-4.1.17-д заасан баримт бичиг.

Тав.Гадаадад суралцах зээл, тэтгэлгийн
сонгон шалгаруулалт

5.1.Боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний шийдвэрээр гадаадын их, дээд сургуульд бакалавр, магистр, докторын хөтөлбөрт суралцах иргэдийг сонгон шалгаруулах Ажлын хэсгийг байгуулж, ажлын удирдамжийг батална.

5.2.Ажлын хэсэг нь зээл, тэтгэлэгт хамрагдахаар хүсэлт гаргасан иргэдийн баримт бичгийг хянаж, шаардлага хангасан тохиолдолд дараагийн шатны сонгон шалгаруулалтад оруулна.

5.3.Сонгон шалгаруулалтын дүнг Ажлын хэсгийн хурлаар хэлэлцэж, хурлын тэмдэглэл, сонгон шалгаруулалтад тэнцсэн иргэдийн нэрсийг дүгнэлтийн хамт боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнд хүргүүлнэ.

5.4.Сонгон шалгаруулалттай холбогдон гарсан маргааныг энэ журмын 5.1-д заасан Ажлын хэсэг шийдвэрлэнэ.

Зургаа.Бусад

6.1.Засгийн газар хооронд байгуулсан олон улсын гэрээ, хэлэлцээрт энэ журамд зааснаас өөрөөр заасан тохиолдолд тухайн гэрээ, хэлэлцээрийн заалтыг дагаж мөрдөнө.

6.2.Боловсролын зээлийн сан нь үйл ажиллагаандаа жил бүр хяналт-шинжилгээ, үнэлгээ хийлгэнэ.

6.3.Боловсролын зээлийн сан нь боловсролын сургалтын байгууллагын үүсгэсэн зээлийн эрсдэлийн сангийн дансны хөрөнгөд хяналт тавьж ажиллана.

6.4.Сургалтын байгууллага нь суралцагчийн санхүүгийн дэмжлэгтэй холбогдох баримт бичгийг улирал бүр Боловсролын зээлийн санд хүргүүлнэ.

6.5.Засгийн газар хоорондын гэрээ хэлэлцээр, хөтөлбөрт зээл, тэтгэлэгт хамрагдаж, гэрээнд заасан хугацаанд суралцаж төгссөн иргэн Монгол Улсад 5-аас доошгүй жил ажилласан байхыг шаардана.

6.6.Давтан үзэх болон тухайн хичээлийн жилд цуглуулбал зохих кредитээс илүү гаргаж сонгосон хичээлийн сургалтын төлбөрийг суралцагч өөрөө хариуцна.

6.7. Энэ журам нь диплом, бакалавр, магистр, докторын хөтөлбөрт хоёр дахь мэргэжил эзэмшихээр суралцаж байгаа болон Боловсролын зээлийн сангийн санхүүжилтээр гадаадын их, дээд сургуульд суралцах эрх авсан, эсхүл суралцаж байгаа иргэнд хамаарахгүй.

6.8.“Монголын сайхан бичигтэн” уралдааныг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага холбогдох төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран зохион байгуулна.

6.9.Энэ журмын 3.6-д заасан тусламжийг төр, хувийн хэвшлийн түншлэлийн хэлбэрээр гадаадын болон олон улсын байгууллагууд, аж ахуйн нэгж, иргэнтэй хамтран ажиллах гэрээгээр зохицуулна.

6.10.Энэ журмыг зөрчсөн этгээдэд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.